

**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	<p>1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас, б/сошиал сувгууд, в/дотоод сүлжээ, г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл, д/мэдээлэл, сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх.</p> <p>1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах.</p>	<ul style="list-style-type: none"> - Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; - Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; - Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн, тайлагнаж хэвших; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших <ul style="list-style-type: none"> - Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх. 	<p>Байгууллагын албан ёсны веб хуудас болон фэйсбүүк цахим хуудсанд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ” сэдэвт нийт 7 видео шторкыг байршуулан, олон нийтэд сурталчилж, 3079 хандалт авсан байна. Үүнд: Эдийн засагч, судлаач Н.Энхбаярын 1 минут 06 секундын шторк 415 хандалт, Гавж Д.Нямсамбуугийн 1 минут 02 секундын шторк 402 хандалт, Доктор С.Дуламын 5 секундын шторк 403 хандалт, Хөтлийн цемент шохойн 1 минут 03 секундын шторк 429 хандалт, ТӨХК-ийн захирал Г.Дугаржавын 1 минут 13 секундын шторк 461 хандалт, ТӨХК-ийн инженер Э.Баярсайханы 1 минут 10 секундын шторк 451 хандалт, Цемент шохой ХХК-ны инженер Х.Алтаншагай 54 секундын шторк 524 хандалтыг тус тус авсан байна.</p> <p>Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар ойлголт мэдээлэл өгөх гарын авлага бэлтгэн веб болон цахим хуудсанд байршуулж, олон нийтэд сурталчилсан.</p> <p>Тус төв нь мэргэжлийн дэглэм бүхий тусгай мэргэжлийн оргүй, үйлчлүүлэгчгүй төв учир Үндэсний төвийн болон ЗӨСТөвүүдийн нийт 410 гаруй ажилтан, албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар баримтлах бодлогын баримт бичиг болон бусад мэдээллийг хүргэн ажиллаж байна.</p> <p>Зоонозын салбарын Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр салбарын онцлогтой үйл ажиллагааны улмаас авлига, ашиг сонирхлын ямар зөрчил үүсч болох, түүнээс хэрхэн урьдчилан</p>

				сэргийлэх талаар Үндэсний төвийн болон орон нутгийн Зоонозын өвчин судлалын төвийн удирдлагууд хэлэлцүүлэг хийж, ямар эрсдэл үүсч болзошгүйг тодорхойлон, цаашид нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад мэдээлэл хүргэж, урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах чиглэл өглөө.
		1.3.Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчилан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилах	- Мэдээллийг авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх, байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийтрүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	Төвийн мэдээллийн самбарт боловсруулсан гарын авлагыг байршуулсан. Гарын авлагыг Авлигатай тэмцэх газраас Эрх бүхий албан тушаалтнуудад илгээсэн сургалтын материалаас шаардлагатай мэдээллүүдийг түүвэрлэн оруулж, бэлтгэсэн болно. Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолоор Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам шинэчлэн батлагдсаныг байршуулж, албан тушаалтнуудад сурталчилж байна. Тус төвийн нийт ажилтан, албан хаагчдад Авлигын эсрэг үйл ажиллагааг байгууллагын албан ёсны цахим хаягаар дамжуулан сурталчилж байна.
		1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон, авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	- Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх.	Тус төв нь мэргэжлийн дэглэм бүхий тусгай мэргэжлийн үйлчлүүлэгчгүй төв учир авлигад өртөх эрсдэл багатай байдаг. Энэ онд Авлигатай тэмцэх газраас бүтээсэн 7 контентийг төвийн албан ёсны веб, цахим хаягаар сурталчилсан.
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн	2.1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	- Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;	Тус төв нь Монгол улсын засгийн газрын 281 дүгээр тогтоолоор Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хамгаалалтад авах улсын онц чухал объектуудын нэг бөгөөд зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих, зоонозын халдварын байгалийн голомтот, зоонозын

	<p>хяналтыг хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; - Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; - Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх. 	<p>өвчнүүдийг тандах, судлах, хянах, эрсдэлээс сэргийлэх, өвчний тохиолдол, дэгдэлт, цар тахал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулж, Нийслэл болон 14 аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв болно.</p> <p>Үйл ажиллагааны өвөрмөц онцлог, био аюулгүй ажиллагаа, био хамгаалал, био халдлагаас сэргийлэх зорилгоор Нууцын тухай хуулийн 13.1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын О.16 дугаар заалт “Эрүүл мэндийн салбарын онц чухал объектын байршил, олгосон газрын нэр зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл нь олон нийтэд нууц байх”-аар тусгагдаж, 2017 оны 283 дугаар тогтоолын “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-ийн дагуу дотоодын цэргийн 05 дугаар ангийн хамгаалалтад зоонозын халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээг зохион байгуулдаг.</p> <p>Иймд Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг тогтмол хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал бөгөөд зоонозын халдварт өвчнөөс сэргийлэх тухай мэдээ, мэдээлэл болон үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээллийг бодитоор иргэд, олон нийт, эрсдэлт бүлгийн хүн амд хүргэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй тогтмол хамтран ажиллах, цахим мэдээллийн хэрэгслийг байгууллагын хэрэгцээнд тулгуурлан тогтмол ашиглаж, олон нийтийн мэдээллийн эрэлт хэрэгцээнд тохирсон мэдээллийг түгээж, шилэн данс болон байгууллагын албан ёсны цахим</p>
	<p>2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх. 	
	<p>2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах</p>	<ul style="list-style-type: none"> - 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол, ойлгомжтой байдлаар мэдээлэх; - Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. 	

				хуудсаар дамжуулан, нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллаж байна.
		2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэ хэвших	- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийг судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; - Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; - Иргэд, олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	Тайлангийн хугацаанд тус төвд 2 иргэнээс өргөдөл гомдол ирүүлснийг шийдвэрлэн ажилласан. Үүнд: 11-11 төвд гаргасан гомдол-1, иргэнээс бичгээр ирүүлсэн өргөдөл гомдол-1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэн, иргэдэд албан бичгээр хариуг хүргүүлсэн. Төвийн албан ёсны веб хуудсаар иргэдээс гомдол мэдээлэл, санал авах тусгай буланг ажиллуулж, нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллаж байна.
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	- Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; - Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; - Хэрэгжилтийг тайлагнах.	Тус төвийн зарим үйл ажиллагаанд E-Health системийг нэвтрүүлэхээр судалж байгаа бөгөөд 2025 онд лабораторийн зарим үйл ажиллагаанд системийг нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна.
		3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	- Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; - Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт	Байгууллагын болон Зоонозын салбарын онцлогт тохируулан нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаагийн бүлгийн хэлэлцүүлэг өрнүүллээ. Уулзалт ярилцлагад 2024 оны 10 дугаар сарын байдлаар шинээр ажилд орсон нийт 12 ажилтан хэлэлцүүлэгт хамрагдсан бөгөөд хүний нөөцийн болон санхүүгийн ил тод байдлыг хангах, зоонозын салбарын хэмжээнд тохиолдож болзошгүй авлига, ашиг сонирхлын зөрчлийн хэлбэр, түүнээс урьдчилан сэргийлэх,

			тохируулан эрсдлийг тодорхойлсон байх; - Эрсдлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх.	зөрчил гаргахгүй ажиллах зэрэг сэдвийн хүрээнд өрнөсөн.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1.Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчиддаа танилцуулах.	- Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; - Албан хаагчдаас гарсан санал, санаачилгыг хэлэлцсэн байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх.	2024 оны 1-р улиралд шуурхай хурал болон бүх ажилтнуудын хурлаар Авлигын эсрэг үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөг танилцуулсан. Мөн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж, хугацаанд нь Эрүүл мэндийн яаманд тайлагнасан бөгөөд хэрэгжилтийг шуурхай хуралд танилцуулсан. Төлөвлөгөөний биелэлт, үр дүнг 2024 оны 12 дугаар сард багтаан бүх ажилтнуудын хурлаар танилцуулахаар төлөвлөж байна.
		4.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Төвийн хөдөлмөрийн дотоод журамд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаарх заалтуудыг тусгасан бөгөөд бусад байгууллагатай байгуулж буй гэрээнд энэ тухай заалтыг тусгайлан оруулсан.
		4.3. Салбарын хэмжээнд 2023 оны эцэс, 2024 оны эхний хагас жилд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд чанарын хяналт хийх	Хяналт-шинжилгээний дүнг тайланд хавсаргасан байна	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй. Төвийн үйл ажиллагаатай холбоотой 2 иргэнээс ирүүлсэн гомдлыг тухай бүр шийдвэрлэн ажилласан.
		4.4. Нийслэлийн эрүүл мэндийн газраас эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Хяналт-шинжилгээний дүнг тайланд хавсаргасан байна	Хамааралгүй
		4.5. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	Хамааралгүй

		4.6. Эрүүл мэндийн яамтай хамтран ажилладаг Төрийн бус байгууллагын гишүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулахад Авлигтай тэмцэх газарт ТББ-уудын мэдээллийг хүргүүлж, дэмжлэг үзүүлэх	Тайланд нотломжийг хавсаргасан байх	Хамааралгүй
		4.7. Эрүүл мэндийн яамны худалдан авах ажиллагааны авлигын эрсдлийг бууруулах зорилгоор энэ чиглэлийн сургалтад алба хаагчдыг хамруулж, үнэлгээний хорооны гишүүдийн тоог нэмэгдүүлэх	Тайланд нотломжийг хавсаргасан байх	Төвийн үнэлгээний хорооны гишүүд болон нийт ажилтнуудад авлигтай тэмцэх газраас Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтын талаарх ойлголтыг мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтыг 12 дугаар сард авахаар албан хүсэлт илгээгээд байна.
5	Байгууллагын авлигын эрсдэлийг бууруулах, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх зорилгоор зайлшгүй тусган хэрэгжүүлэх арга хэмжээ	5.1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдүүлэх.	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	Хамааралгүй
		5.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээн дэх авлигын хэлбэр, шалтгаан нөхцлийг тодорхойлох зорилгоор авлигын эрсдлийн үнэлгээ хийх	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	Төвийн авлигын эрсдлийн үнэлгээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, төсвийг батлуулж, хэрэгжүүлнэ.
		5.3. “Зөвшөөрлийн цахим систем”-д эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлэх	Шударга байдлын үнэлгээний оноо нэмэгдсэн байна.	Хамааралгүй

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Тус төвийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АМГАЛАНБАЯР